

31 Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын
...-ны өдрийн... дугаар тушаалын тавдугаар хавсралт



ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн томилогдсон Өмч хамгаалах байнгын зөвлөл /цаашид ӨХБЗ гэх/ нь энэхүү журмыг мөрдөж ажиллана. Үндсэн зорилго нь байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хяналтыг зохион байгуулах талаар өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулахад оршино. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүн нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Хоёр. Өмч хамгаалах байнгын зөвлөл

- 2.1 Өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын эд хөрөнгийг эзэмших, зөв зохистой ашиглах, үр ашгийг дээшлүүлэхэд эрх зүйн зөвлөгөөг өгөх, бүртгэл хөтлөх, бүртгэлтэй хөрөнгийг шилжүүлэх, худалдах, акталж, дансаас хасах, устгах, бүртгэлгүй эд хөрөнгийн талаар санал дүгнэлт гаргаж Гүйцэтгэх захирлын зөвлөлд тайлагнах, холбогдох материалыг бүрдүүлж Төлөөлөн удирдах зөвлөл болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж ажиллана.
- 2.2 Зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, болон бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг мөрдлөг болгоно.
- 2.3 Зөвлөлийг Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулна.

Гурав. Зөвлөлийн эрх үүрэг

- 3.1 Зөвлөл нь байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар жил бүр ажлын төлөвлөгөө гарган Гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөж ажиллана.
- 3.2 Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа зохион байгуулж дутагдсан, шамшигдсан, ашиглалтгүй байгаа, цаашид ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийн шалтгааныг тогтоож дүгнэлт гарган Гүйцэтгэх захирлын зөвлөлд танилцуулж шийдвэр гаргуулна.

- 3.3 Эд хөрөнгийн элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ нөхсөн, эсхүл ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлийн улмаас эвдэрч гэмтэн цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгөнд дүгнэлт гаргаж Гүйцэтгэх захирлын шийдвэр гаргуулж буруутай этгээдээр хохирлыг төлүүлнэ.
- 3.4 Хөрөнгийн тооллого, бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд тавих хяналтыг дотоод хяналтын нэгжтэй хамтран зохион байгуулж холбогдох санал дүгнэлтээ бичгээр гарган Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн дэд захиралд танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 3.5 Байгууллагын эд хөрөнгөтэй холбоотой асуудлыг Гүйцэтгэх захирлын зөвлөл хэлэлцэхэд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд оролцож санал гаргах эрхтэй.
- 3.6 Зөвлөлөөс тухайн жилд зохиосон ажил, түүний үр дүн, байгууллагын өмчийн бүртгэл тооллого, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргийг тусгасан ажлын тайланг гаргаж жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор Гүйцэтгэх захирлын зөвлөлд танилцуулж гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

Дөрөв. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал

- 4.1 Өмч хамгаалах байнгын зөвлөл нь шаардлагатай үед хурлаа хийж гаргасан шийдвэрээ Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн дэд захиралд танилцуулна.
- 4.2 Зөвлөлийн дарга хурлыг товлож, нарийн бичгийн даргаар дамжуулан бусад гишүүдэд зарлан мэдээлэх, хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг холбогдох ажилтан хурал төвлөсөн өдрөөс нэг хоногийн өмнө зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлж, шаардлагатай тохиолдолд өөрийн биеэр хуралд танилцуулга, тайлбар хийнэ.
- 4.3 Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд гишүүдийн дийлэнх олонхи оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. Хуралдаанд гишүүд саналын тэгш эрх эдлэх бөгөөд олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 4.4 Зөвлөлийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг 3 хувь үйлдэнэ. Хуралдааны тэмдэглэл, шийдвэрийн 1 хувийг албан хэрэгт, 1 хувийг байгууллагын захиргаанд хүргүүлнэ.

Тав. Хариуцлага

- 5.1 Энэ журмаар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, ёс зүйн алдаа зөрчил гаргасан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүн холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. /байгууллагын дотоод журам, бусад холбогдох хууль тогтоомж, заавар, журам гэх мэт.../